



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

163 /163/

2021.10.25

ҮЙЛ ЯВДАЛ

## ОНОЛ, ДАДЛАГА ХОСЛУУЛНА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах заавар", "Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөө"-г үндэслэн нэгтгэл, ангиудын 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт

бэлтгэлийн төлөвлөгөөг 2021 оны 9 дүгээр сарын 23-аас 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд боловсруулж Хуурай замын цэргийн штабын даргаар нэгтгэл, ангиудын сургалтын офицерууд батлуулсан. Тус зохион байгуулах заавраар "Давших байлдааныг бэлтгэх, явуулах"-д бүх төрлийн сургалтыг чиглүүлэн онол, дадлага хослуулан явуулахаар төлөвлөөд байна.

Түүхэнд энэ өдөр

1854 он:

Их Британи, Франц, Туркийн холбоотнуудын хүчин ба Оросын цэргийн хооронд 1853–1856 онуудад явагдсан Крымын дайны явцад Балаклавскийн тулалдаан болов.

1922 он:

Зөвлөлт Оросын иргэний дайн дуусав.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 7	☁️ -10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,850.0	2,853.0
EUR 🇪🇺	3,315.0	3,325.0
CNY 🇨🇳	445.0	446.0
RUB 🇷🇺	39.90	41.60
JPY 🇯🇵	24.76	25.31
KRW 🇰🇷	2.34	2.47

### ЗУРХАЙ

2021.10.25 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 20/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
07.26-17.46

Барилдлага:

Үл зохилдох  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Хүрэлцэхүй

Суудал:  
Шороо

Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба гарагийг тахиж, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулган, үхэр, морь, бич, тахиа, болой. Хол газар яваар одогсод баруун урагшаа мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## ЦЭЦЭЭ ГҮНИЙ НОЁН ОРГИЛ РУУ ЯВГАН АЯЛАЛ ХИЙВ



Хуурай замын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн 2021-2022 оны хичээлийн шинэ жилийг тохиолдуулан Төв аймгийн

нутаг дэвсгэрт орших Цэцээ гүний ноён оргил руу /8 км/ явган аялал хийлээ. Энэхүү явган аяллын гол зорилго нь ирэх хичээлийн



шинэ жилд амжилт бүтээл арвин байхыг ерөөж уул ус, баян хангайдаа сүсэглэн залбирах, хийморь сүлдээ сэргээх, хамт олны эв

нэгдлийг бэхжүүлэх, мөн Цэцээ гүний оргил орчмын хогийг цэвэрлэх, байгаль орчноо хайрлан хамгаалахад оршсон юм.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
342,063 +1321

ЭДГЭРСЭН  
458,976

НАС БАРСАН  
1587 v+17

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
5898 +101

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
264

ЭДГЭРСЭН  
5521

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 244,424,171

Эдгэрсэн

Нийт: 221,444,540

Нас барсан

Нийт: 4,963,663

Цахим шууданд

## ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТААР ...



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

2021-2022 оны сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагаагаа зохион байгуулж нэгтгэлийн удирдлага, штабын офицерууд, салаа, салбарын захирагч нар болон даргалах албан тушаалын ахлагч нартай заах арга зүйн цугларалт явуулж байна. Энэ удаагийн цугларалт нь "Цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөж, зохион байгуулахад албан тушаалтнуудын үүрэг оролцоо" сэдвийн хүрээнд "Цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдан зохион байгуулах үр чадварыг дээшлүүлж, багшлах бүрэлдэхүүний хичээл заах арга зүйг нэмэгдүүлэх" зорилготой юм. Заах арга зүйн цугларалт хоёр өдөр үргэлжилнэ.

## ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТЫН ХҮРЭЭНД ...



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн заах арга зүйн цугларалт амжилттай явагдаж өндөрлөлөө. Энэ удаагийн заах аргын цугларалт нь "Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам" сэдвийн хүрээнд явагдан "Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн бодлого", "Анги салбарын жигдрэлт", "Бэлэн байдлыг хангах сургалтыг явуулах онцлог", "Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөлт, онцлог", "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", "Сэтгэл зүйн бэлтгэл, цэргийн сургалт бэлтгэлийн уялдаа холбоо", "Байгууллагын соёл гэж юу вэ?" гэх мэт сэдвээр явагдлаа. Мөн энэ үеэр Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын багш Б.Наранцэцэгийг урьж "Багаар ажиллах арга зүй" сэдвээр яриа таниулга хийлгэсэн юм.

Дэслэгч Г.НАНДИНЧИМЭГ

## 2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

2021-2022 оны сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагаа амжилттай боллоо. Үйл ажиллагааг ангийн захирагч, дэд хурандаа Б.Даваа-Очир нээж бие бүрэлдэхүүнд хандан үг хэлсэн бол Цаг уурын хангалтын тасгийн уур амьсгалын инженер, дэслэгч Н.Бат-Энх залуу офицеруудыг төлөөлж сэтгэгдлээ хуваалцсан юм. Түүнчлэн ХЦДБЧ-ын дуучин ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

# ҮБХИС-ИЙН 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН БҮТЭЭЛҮҮД

Монгол Улсын цэргийн мэргэжлийн боловсролын ууган байгууллага болох Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн түүхт 100 жилийн ойг угтан тус сургуулийн нийт хамт олны хүчин чармайлтын үрээр "ҮБХИС нэгэн зуунд" түүхийн ном, "ҮБХИС нэгэн зуунд" гэрэл зургийн цомгийг бүтээлээ.

"ҮБХИС нэгэн зуунд" бүтээлийг Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Ш. П а л а м д о р ж и й н удирдлагад цэргийн түүхийн ухааны доктор (Ph.D), дэд профессор Т.Сүхбаатар, И.Чинбат тэргүүтэй тус сургуулийн олон багш, судлаач зохиогчоор оролцсон юм.

"Үндэсний батлан хамгаалахын их сургууль-нэгэн зуунд" гэсэн энэ бүтээл, одоогоос хорин жилийн өмнө хэвлэн нийтлүүлсэн "Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль"

өдгөө архивын сан хөмрөгт хадгалагдаж байна.

Тухайлбал, "Краткая история Объединенного военного училища МНКА" (Монгол ардын улаан цэргийн Бүх ерөнхий сургуулийн товч түүх) хэмээх орос хэлээр бичиж, бичгийн машинаар цохсон 32 хуудас материал Монгол Улсын үндэсний төв архивт бий. Энэхүү товч түүхийг зохиогч нэрээ бичээгүй боловч, хориод онд тус сургуульд ажиллаж байсан орос сургагч нарын нэг буюу (хэсэг сургагч) бичсэн нь тодорхой байдаг. Энэ товч түүхэнд 1921 оны зун, намраас 1928.06.21 хүртэлх долоон жилийн үйл явдлыг дараалан маш тодорхой бичиж үлдээсэн нь чухал үнэ цэнтэй хэрэглэгдэхүүн юм.

Цэргийн ерөнхий сургуулийн МАХН-ын түүхийн багш Ш.Жамсранжавын бичсэн "Жанжин Сүхбаатарын нэрэмжит Улаан тугийн одон тэмдэгт Ардын цэргийн Ерөнхий

хэмээх 187 хуудастай гар бичмэлийг тус сургуулийн 50 жилийн ойд зориулан 1971 онд бичжээ. Энэхүү түүхийг Цэргийн дээд сургуулийн улс төрийн хэлтсийн дарга, хурандаа Ч.Данзанбалжир удирдаж, түүхийн багш Б.Гова, улс төрийн ажилтан н.Самбуу нарын зохиогч бичсэн байна.

"Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Цэргийн нэгдсэн дээд сургуулийн дэлгэрэнгүй түүх" 508 хуудастай гар бичмэл бүтээлийг ахмад багш Б.Гова дэд доктор, доцент Б.Банзрагч нар 1990 онд бичжээ. Монгол Улсын Батланхамгаалахын их сургуулийн түүхийн хураангуй ном, гэрэл зургийн цомгийг 2001 онд захирал Д.Мягмарын санаачилгаар Батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд хамтран туурвижээ.

БХИС-ийн 85 жилийн ойгоор 2006 онд захирал Н.Жалбажавын санаачилгаар "Ууган сургуулийн буурал түүхийн дурсамж" гэсэн нэртэй тус сургуульд он удаан жил ажилласан 66 хүний дурсамжийг хэвлэн нийтлүүлж, гэрэл зургийн цомгоор түүхээ бодит баримтаар баяжуулсан байна.

БХИС-ийн 90 жилийн ойгоор 2011 онд захирал З.Болдбаатарын санаачилга болон доктор (Sc.D), профессор Г.Мягмаржав, доктор (Ph.D), профессор Г. М я г м а р с а м б у у нарын удирдлагаар тус сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн түүхийн ахлах багш, доктор (Ph.D) И.Чинбат "Батлан хамгаалахын их сургууль-90 жил" хэмээх номыг зохион эмхэтгэж хэвлэн нийтлүүлсэн байна. Энэхүү бүтээлд өмнөх 80 жилийн ойд зориулсан номын агуулгыг хураангуйлан оруулснаас гадна сүүлийн арван жил (2001-2011 оны) -ийн түүхийг шинэчлэн бичсэн, гэрэл зураг, түүхэн баримтуудыг хавсарган оруулсан онцлогтой юм.

БХИС-ийн 95 жилийн ойг угтаж захирал Я.Чойжамцын идэвхтэй оролцоогоор "Батлан хамгаалахын их сургуулийн түүхэн замнал-95 жилд" эрдэм шинжилгээний сурах ангийн орлогч "эх оронч" хэмээн алдаршсан дэд хурандаа Доржийн Баадайн санаачилга, даалгавраар зохиогч бичжээ.

"Ж а н ж и н Д.Сүхбаатарын нэрэмжит Сүхбаатарын ба Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цэргийн дээд сургуулийн түүх" бүтээл нь Цэргийн ерөнхий сургуулийг 1956 оны 5 дугаар сард татан буулгахтай холбогдуулан зохиогдсон бөгөөд эл түүхийг тус сургуулийн сурах ангийн орлогч "эх оронч" хэмээн алдаршсан дэд хурандаа Доржийн Баадайн санаачилга, даалгавраар зохиогч бичжээ.

бүтцийн нэгжүүд өөр өөрсдийн түүхийг бичиж нийтлүүлсээр ирсэн байна.


Тэгвэл энэ жил 100 жилийн ойд зориулан "Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль-нэгэн зуунд" гэсэн энэхүү бүтээл нь агуулга, арга зүйн хувьд өмнөх түүхийн хураангуйн үргэлжлэл, тодотгол, судалгаа, сурталчилгааны нэг сэдэвт бүтээл болохоор тус сургуулийн түүхэн үечлэлд "Шинэ зууны Үндэсний батлан хамгаалахын их сургууль" гэсэн нэгэн үе, номын бүлгийг нэмэн тодруулж байна.

Бидний хэвлэн нийтлүүлж буй "Үндэсний батлан хамгаалахын их сургууль - нэгэн зуунд" гэсэн энэ бүтээл одоогоос хорин жилийн өмнө хэвлэн нийтлүүлсэн "Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль" (түүхийн хураангуй) номын үндсэн агуулгыг баяжуулсан, сүүлийн хорин жилийн түүхэн үйл явдлыг нэмэн оруулсан өнөө цагийн өндөрлөгөөс түүхээ эргэн нэг харж тодотгосон 8 бүлгээс бүрдсэн 37.8 хэвлэлийн хуудас бүхий бүтээл болно.

Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Ш. П а л а м д о р ж и й н тодорхойлсноор

"Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль - Нэгэн зуунд" гэсэн энэхүү бүтээл Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн яруу алдарт нэгэн зууны түүхэн замналыг олон нийтэд таниулах, энэ сургуульд суралцаж, ажиллаж байсан үе үеийн хүмүүс түүгээрээ бахархах, төрөлх сургуулиа хайрлан хүндэтгэх, бэлтгэн гаргаж буй цэргийн болон иргэний төрөл бүрийн мэргэжлийн офицер, мэргэжилтнүүдээ алдаршуулах, залуу үеийнхэнд эх оронч ухамсар, ёс суртахуун, хүмүүжил, сэтгэл зүй, оюун санааны эрхэм чанар төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэгсэн гол зорилготой сургуулийн зуун жилийн ойд зориулсан бүтээл" юм.

Ж а н ж и н Д.Сүхбаатарын нэрэмжит, Сүхбаатарын ба Байлдааны гавьяаны улаан тугийн болон Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн түүхтэй холбоотой материал цуглуулж, ном бичихэд оролцсон хүн бүхэнд сургуулийн удирдлага, зохиогчид, хянан тохиолдуулагч нараас чин сэтгэлийн талархал илэрхийлье.



(түүхийн хураангуй) номын үндсэн агуулгыг баяжуулсан, сүүлийн хорин жилийн түүхэн үйл явдлыг нэмэн оруулсан, өнөө цагийн өндөрлөгөөс түүхээ эргэн нэг харж тодотгосон болой.

ҮБХИС-ийн түүхийг улираан судалж, ном дэвтэр, гэрэл зургийн цомогт тэмдэглэн үлдээсэн нь цөөнгүй байдаг. Ардын цэргийн даргын сургууль-Цэргийн бүх ерөнхий сургууль-Цэргийн дээд сургуулийн түүхийг хэд хэдэн удаа бичиж фото хэлбэрээр үлдээсэн нь

сургуулийн түүх" бүтээл нь Цэргийн ерөнхий сургуулийг 1956 оны 5 дугаар сард татан буулгахтай холбогдуулан зохиогдсон бөгөөд эл түүхийг тус сургуулийн сурах ангийн орлогч "эх оронч" хэмээн алдаршсан дэд хурандаа Доржийн Баадайн санаачилга, даалгавраар зохиогч бичжээ.

"Ж а н ж и н Д.Сүхбаатарын нэрэмжит Сүхбаатарын ба Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цэргийн дээд сургуулийн түүх"